



НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Нийслэлийн Чингэлтэй дүүргийн хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтсийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**Аудитын код: ХАК-2022/785/НА-СА-ТШЗ**

Цахим хуудас: [www.audit.mn](http://www.audit.mn)

Улаанбаатар хот

2022 он

Эвиденсе аудит ХХК захирал,

Ахлах аудитор: С.Бадамгарав

Утас: 99057121

Цахим хаяг: [info@evidenceaudit.mn](mailto:info@evidenceaudit.mn)

Аудитор: Б.Пушкин

Утас: 95047121

Цахим хаяг: [pushkin@evidenceaudit.mn](mailto:pushkin@evidenceaudit.mn)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



## Агуулга

1. Аудитын санал дүгнэлт .....	
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл.....	2
3. Аудитын тайлан .....	11
3.1 Ерөнхий зүйл.....	11
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт.....	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	12
3.4 Материаллаг байдал.....	12
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	12
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	12
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг .....	14
3.8 Аудитын гол асуудал.....	14
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	14
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	15
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	15
4. Аудитын илрүүлэлт .....	15
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл .....	15

### Товчилсон үгийн жагсаалт

НТАГ	Нийслэл дэх Төрийн аудитын газар
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТШЗ	Төсвийн шууд захирагч



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
НИЙСЛЭЛ ДЭХ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,  
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөн, Г корпус, 5 давхар,  
Утас: 7000 7734, Факс: (976-11) 32 01 54,  
И-мэйл: ubi@audit.gov.mn, Вэбсайт: www.audit.mn

2022.02.24 № 311

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

НИЙСЛЭЛИЙН ЧИНГЭЛТЭЙ  
ДҮҮРГИЙН ХӨДӨЛМӨР,  
ХАЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ  
ХЭЛТСИЙН ДАРГА А.СЭРЭЭТЭР  
ТАНАА

**АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ**

**Зерчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Нийслэлийн Чингэлтэй дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтсийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Нийслэлийн Чингэлтэй дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтсийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

002020282



### Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ  
АУДИТОР



М.ЭРДЭНЭЖАРГАЛ

## 2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/			
Дансны код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>30,797,514.98</b>	<b>29,575,245.65</b>
33	<b>АВЛАГА</b>	<b>58,124.00</b>	<b>1,999.57</b>
335	<b>Бусад авлага</b>	<b>58,124.00</b>	<b>1,999.57</b>
3352	Хувь хүмүүсээс авах авлага	58,124.00	1,999.57
35	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>30,739,390.98</b>	<b>29,573,246.08</b>
354	<b>Хангамжийн материал</b>	<b>30,739,390.98</b>	<b>29,573,246.08</b>
35410	Бичиг хэргийн материал	7,187,470.00	8,996,157.00
35420	Аж ахуйн материал	20,242,273.01	19,814,693.01
35430	Сэлбэг хэрэгсэл	7,700.00	7,700.00
35440	Түлш шатах тослох материал	2,616,537.97	374,496.07
35450	Барилгын засварын материал	295,710.00	52,500.00
35470	Бусад хангамжийн материал	389,700.00	327,700.00
2	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>670,789,460.45</b>	<b>636,908,011.45</b>
39	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>670,789,460.45</b>	<b>636,908,011.45</b>
392	<b>Биет хөрөнгө</b>	<b>619,316,660.50</b>	<b>589,926,044.83</b>
39201	Барилга, байгууламж	669,684,460.00	669,684,460.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(144,577,639.97)	(161,689,034.33)
39203	Авто тээврийн хэрэгсэл	39,000,000.00	39,000,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(24,375,000.00)	(28,275,000.00)
39205	Машин, тоног төхөөрөмж	283,127,950.56	230,524,455.85
39206	Хуримтлагдсан элэгдэл	(235,707,010.25)	(188,838,553.95)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	85,254,414.11	88,895,260.72
39208	Хуримтлагдсан элэгдэл	(53,090,513.95)	(59,375,543.46)
39214	Бусад үндсэн хөрөнгө	80,000.00	80,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(80,000.00)	(80,000.00)
393	<b>Биет бус хөрөнгө</b>	<b>51,472,799.95</b>	<b>46,981,966.62</b>
39301	Програм хангамж	16,656,900.00	16,656,900.00
39302	Хасагдуулга	(6,424,400.05)	(10,915,233.38)
39303	Бусад биет бус хөрөнгө	41,240,300.00	41,240,300.00
3	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>701,586,975.43</b>	<b>666,483,257.10</b>
4	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН</b>	<b>52,002.01</b>	<b>28,340.65</b>
41	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>52,002.01</b>	<b>28,340.65</b>
413	<b>Өглөг</b>	<b>52,002.01</b>	<b>28,340.65</b>
41310	Ажиллагчидтай холбогдсон өглөг	0.00	28,340.65
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	52,002.01	-
5	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН</b>	<b>701,534,973.42</b>	<b>666,454,916.45</b>
51	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b>701,534,973.42</b>	<b>666,454,916.45</b>
511	<b>Засгийн газрын оруулсан капитал /ЗГСан/ орон нутгийн сан</b>	<b>207,355,556.62</b>	<b>207,355,556.62</b>
51101	Өмч: -Төрийн өмч	207,355,556.62	207,355,556.62
512	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>395,803,881.03</b>	<b>361,373,653.57</b>
51210	Өмнөх үеийн үр дүн	395,803,881.03	396,453,710.54
51220	Тайлант үеийн үр дүн	-	(35,080,056.97)
51300	<b>Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү</b>	<b>98,375,535.77</b>	<b>97,725,706.26</b>
6	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>701,586,975.43</b>	<b>666,483,257.10</b>



## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	/төгрөгөөр/	
		Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>949,739,920.00</b>	<b>930,296,256.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>55,816,120.00</b>	<b>16,722,256.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>55,816,120.00</b>	<b>16,722,256.00</b>
<b>120004</b>	<b>Төсөвт байгууллагын өөрийн орлого</b>	<b>55,816,120.00</b>	<b>16,722,256.00</b>
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	49,605,320.00	15,756,136.00
1200046	Зээлийн хүүгийн орлого	6,210,800.00	966,120.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>893,923,800.00</b>	<b>913,574,000.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>865,183,800.00</b>	<b>894,574,000.00</b>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	865,183,800.00	894,574,000.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>28,740,000.00</b>	<b>19,000,000.00</b>
131103	ЗГНХ, Засаг даргын нөөц хөрөнгө түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөнөөс	4,740,000.00	-
131104	Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захи	24,000,000.00	19,000,000.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН (II)</b>	<b>931,088,265.78</b>	<b>965,376,312.97</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>931,088,265.78</b>	<b>965,376,312.97</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>915,931,603.70</b>	<b>923,999,389.68</b>
<b>2101</b>	<b>Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>647,872,390.24</b>	<b>650,321,752.74</b>
210101	Цалин	647,872,390.24	570,455,590.31
210102	Нэмэгдэл цалин	-	53,041,662.43
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	26,824,500.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>86,889,374.63</b>	<b>92,029,245.56</b>
210201	Тэтгэврийн даатгалын шимтгэл	60,698,269.11	66,843,931.85
210202	Тэтгэмжийн даатгалын шимтгэл	7,154,544.29	7,806,378.78
210203	ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	5,273,397.04	4,976,351.06
210204	Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	1,262,703.50	1,249,915.71
210205	Эрүүл мэндийн даатгалын хураамж	12,500,460.69	11,152,668.17
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>79,202,685.56</b>	<b>74,232,396.89</b>
210301	Гэрэл цахилгааны зардал	17,074,118.00	12,712,237.90
210303	Цэвэр, бохир усны зардал	3,914,733.56	1,678,657.99
210304	Байрны түрээс	58,213,834.00	59,841,501.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>25,934,168.78</b>	<b>26,720,464.49</b>
210401	Бичиг хэргийн материал	8,957,248.00	8,977,213.00
210402	Тээвэр, шатахууны зардал	4,134,109.10	4,071,941.90
210403	Шуудан холбоо интернэтийн төлбөр	5,728,472.99	3,999,519.59
210405	Хог хаягдал устгах, цэвэрлэх	-	64,000.00
210406	Бага үнэ түргэн элэгдэл зүйлс	7,114,338.69	8,751,040.00
210408	Бараа материал акталсны зардал	-	856,750.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>2,708,000.00</b>	<b>3,439,350.00</b>
210601	Багаж хэрэгсэл	308,000.00	-
210604	Урсгал засвар	2,400,000.00	3,439,350.00



2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж</b>	<b>17,831,130.00</b>	<b>25,163,305.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,000,000.00	10,000,000.00
210802	Аудит, баталгаажуулалт зэрэглэл тогтоох зардал	12,500,000.00	12,500,000.00
210803	Даатгалын үйлчилгээний төлбөр	464,100.00	557,100.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	60,104.00	59,984.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	20,000.00	-
210806	Мэдээллийн технологийн үйлчилгээний хөлс	1,065,326.00	1,615,103.00
210807	Газрын төлбөр	721,600.00	431,118.00
2109	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>55,493,854.49</b>	<b>52,092,875.00</b>
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	55,493,854.49	52,092,875.00
213	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>15,156,662.08</b>	<b>41,376,923.29</b>
2132	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>12,318,000.00</b>	<b>39,601,400.00</b>
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	11,150,000.00	38,701,400.00
213209	Нэг удаагийн тэтгэмж шагнал урамшуулал	1,168,000.00	900,000.00
2133	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>2,838,662.08</b>	<b>1,775,523.29</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,431,129.18	1,775,523.29
213304	Хөрөнгийн	1,407,532.90	-
3	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III=I-II)</b>	<b>18,651,654.22</b>	<b>(35,080,056.97)</b>
5	<b>НИИТ ҮР ДҮН (VII=III+VI)</b>	<b>18,651,654.22</b>	<b>(35,080,056.97)</b>

### 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C08	2020 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	207,355,556.62	98,375,535.77	395,803,881.03	701,534,973.42
D01	2020 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	207,355,556.62	98,375,535.77	395,803,881.03	701,534,973.42
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	649,829.51	649,829.51
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	207,355,556.62	98,375,535.77	396,453,710.54	702,184,802.93
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	(649,829.51)	-	(649,829.51)
D08	Тайлант үеийн үр дүн /Цэвэр ашиг алдагдал/	-	-	(35,080,056.97)	(35,080,056.97)
D09	2021 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	207,355,556.62	97,725,706.26	361,373,653.57	666,454,916.45

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	/төгрөгөөр/	
		Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>893,923,800.00</b>	<b>913,574,000.00</b>
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>893,923,800.00</b>	<b>913,574,000.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>865,183,800.00</b>	<b>894,574,000.00</b>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	865,183,800.00	894,574,000.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>28,740,000.00</b>	<b>19,000,000.00</b>
131103	ЗГНХ, ЗДНХ түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөнөөс	4,740,000.00	-
131104	Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	24,000,000.00	19,000,000.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (II)</b>	<b>887,576,100.00</b>	<b>911,118,710.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>887,576,100.00</b>	<b>911,118,710.00</b>
<b>210</b>	<b>БАРАА АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>872,419,437.92</b>	<b>869,741,786.71</b>
<b>2101</b>	<b>Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>647,956,875.55</b>	<b>650,481,833.22</b>
210101	Үндсэн цалин	473,000,465.36	479,672,122.58
210102	Нэмэгдэл	124,323,035.98	115,818,754.49
210103	Унаа хоолны хөнгөлөлт	50,633,374.21	54,990,956.15
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>86,390,520.82</b>	<b>91,784,700.00</b>
210201	Тэтгэврийн даатгалын шимтгэл	61,016,331.00	66,126,300.00
210202	Тэтгэмжийн даатгалын шимтгэл	6,526,343.56	6,414,600.00
210203	ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	5,131,699.52	5,131,700.00
210204	Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	1,282,899.70	1,282,900.00
210205	Эрүүл мэндийн даатгалын хураамж	12,433,247.04	12,829,200.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалтай холбоотой тогтмол зардал</b>	<b>79,104,208.56</b>	<b>74,284,398.90</b>
210301	Гэрэл цахилгааны зардал	17,074,118.00	12,712,237.90
210303	Цэвэр, бохир усны зардал	3,816,256.56	1,730,660.00
210304	Байрны түрээс	58,213,834.00	59,841,501.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>38,384,702.99</b>	<b>24,501,049.59</b>
210401	Бичиг хэрэг	11,334,770.00	10,990,780.00
210402	Тээвэр, шатахуун	6,191,250.00	1,829,900.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	7,158,472.99	3,632,519.59
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	-	64,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	13,700,210.00	7,983,850.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>2,708,000.00</b>	<b>3,206,500.00</b>
210601	Багаж техник хэрэгсэл	308,000.00	-
210604	Урсгал засвар	2,400,000.00	3,206,500.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>17,875,130.00</b>	<b>25,483,305.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр хураамж	3,000,000.00	10,000,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	12,500,000.00	12,500,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	464,100.00	557,100.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	60,104.00	59,984.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	20,000.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,109,326.00	1,935,103.00





210807	Газрын төлбөр	721,600.00	431,118.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>15,156,662.08</b>	<b>41,376,923.29</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>12,318,000.00</b>	<b>39,601,400.00</b>
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	11,150,000.00	38,701,400.00
213209	Нэг удаагийн тэтгэмж шагнал урамшуулал	1,168,000.00	900,000.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>2,838,662.08</b>	<b>1,775,523.29</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,431,129.18	1,775,523.29
213304	Хөрөнгийн	1,407,532.90	-
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)</b>	<b>6,347,700.00</b>	<b>2,455,290.00</b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)</b>	<b>6,347,700.00</b>	<b>2,455,290.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>6,347,700.00</b>	<b>2,455,290.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>6,347,700.00</b>	<b>2,455,290.00</b>
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	6,347,700.00	2,455,290.00
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)</b>	<b>(6,347,700.00)</b>	<b>(2,455,290.00)</b>

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	Хувь
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БАЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>894,574,000.00</b>	<b>892,798,476.71</b>	<b>1,775,523.29</b>	<b>99.80%</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>894,574,000.00</b>	<b>892,798,476.71</b>	<b>1,775,523.29</b>	<b>99.80%</b>
<b>210</b>	<b>Бараа, үйлчилгээний зардал</b>	<b>854,937,800.00</b>	<b>853,197,076.71</b>	<b>1,740,723.29</b>	<b>99.80%</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>650,961,000.00</b>	<b>650,481,833.22</b>	<b>479,166.78</b>	<b>99.93%</b>
210101	Үндсэн цалин	476,201,500.00	479,672,122.58	(3,470,622.58)	100.73%
210102	Нэмэгдэл	126,480,500.00	115,818,754.49	10,661,745.51	91.57%
210103	Унаа, болон бусад	48,279,000.00	54,990,956.15	(6,711,956.15)	113.90
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос НД-дтөлөх шимтгэл</b>	<b>91,784,700.00</b>	<b>91,784,700.00</b>	<b>-</b>	<b>100%</b>
210201	Тэтгэврийн даатгал	66,126,300.00	66,126,300.00	-	100%
210202	Тэтгэмжийн даатгал	6,414,600.00	6,414,600.00	-	100%
210203	ҮОМШӨ ний даатгал	5,131,700.00	5,131,700.00	-	100%
210204	Ажилгүйдлийн даатгал	1,282,900.00	1,282,900.00	-	100%
210205	Эрүүл мэндийн даатгал	12,829,200.00	12,829,200.00	-	100%
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>74,415,500.00</b>	<b>74,284,398.90</b>	<b>131,101.10</b>	<b>99.82%</b>
210301	Гэрэл цахилгаан	12,663,800.00	12,712,237.90	(48,437.90)	100.38%
210303	Цэвэр, бохир ус	1,831,700.00	1,730,660.00	101,040.00	94.48%
210304	Байрны түрээс	59,920,000.00	59,841,501.00	78,499.00	99.87%
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>17,315,000.00</b>	<b>16,501,049.59</b>	<b>813,950.41</b>	<b>95.30%</b>
210401	Бичиг хэрэг	5,332,400.00	5,331,780.00	620.00	99.99%
210402	Тээвэр (шатахуун)	1,831,600.00	1,829,900.00	1,700.00	99.91%
210403	Шуудан холбоо, интернэтийн төлбөр	2,780,900.00	2,102,519.59	678,380.41	75.61%
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	196,600.00	64,000.00	132,600.00	32.55%
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, аж ахуйн эд зүйлс	7,173,500.00	7,172,850.00	650.00	99.99%
<b>2106</b>	<b>Эд хогшил худалданавах</b>	<b>5,832,200.00</b>	<b>5,661,790.00</b>	<b>170,410.00</b>	<b>97.08%</b>

210601	Багаж, техник, хэрэгсэл	2,550,600.00	2,455,290.00	95,310.00	96.26%
210604	Урсгал засвар	3,281,600.00	3,206,500.00	75,100.00	97.71%
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр</b>	<b>14,629,400.00</b>	<b>14,483,305.00</b>	<b>146,095.00</b>	<b>99.00%</b>
210802	Аудит, баталгаажуулалт зэрэглэл тогтоох зардал	12,500,000.00	12,500,000.00	-	100%
210803	Даатгалын үйлчилгээ	557,100.00	557,100.00	-	100%
210804	Тээврийн хэрэгслийн татвар	60,400.00	59,984.00	416.00	99.31%
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	22,000.00	-	22,000.00	-
210806	Мэдээллийн технологийн зардал	1,000,800.00	935,103.00	65,697.00	93.44%
210807	Газрын төлбөр	489,100.00	431,118.00	57,982.00	88.15%
	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>39,636,200.00</b>	<b>39,601,400.00</b>	<b>34,800.00</b>	<b>99.91%</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгалшилжүүлэг</b>	<b>39,636,200.00</b>	<b>39,601,400.00</b>	<b>34,800.00</b>	<b>99.91%</b>
213207	Тэтгэвэрт гарахад нь олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	38,701,400.00	38,701,400.00	-	100%
213209	Нэг удаагийн тэтгэмж журамшуулал	934,800.00	900,000.00	34,800.00	96.28%
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>894,574,000.00</b>	<b>892,798,476.71</b>	<b>1,775,523.29</b>	<b>99.80%</b>
<b>1310</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>894,574,000.00</b>	<b>892,798,476.71</b>	<b>1,775,523.29</b>	<b>99.80%</b>
131001	Улсын төсвөөс санхүүжих	894,574,000.00	892,798,476.71	1,775,523.29	99.80%
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСДЫН ТОО</b>	<b>57.00</b>	<b>57.00</b>	-	100%
620001	Удирдах ажилтан	1.00	1.00	-	100%
620002	Гүйцэтгэх ажилтан	48.00	48.00	-	100%
620003	Үйлчлэх ажилтан	8.00	8.00	-	100%

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл /төгрөгөөр/
<b>2</b>	<b>I. НИИТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>19,000,000.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>19,000,000.00</b>
<b>210</b>	<b>Бараа, үйлчилгээний зардал</b>	<b>19,000,000.00</b>
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>8,000,000.00</b>
210401	Бичиг хэрэг	5,659,000.00
210403	Шуудан холбоо, интернэтийн төлбөр	1,530,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, аж ахуйн эд зүйлс	811,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр</b>	<b>11,000,000.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	10,000,000.00
210806	Мэдээллийн технологийн зардал	1,000,000.00
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>19,000,000.00</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>19,000,000.00</b>
131104	Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	19,000,000.00
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСДЫН ТОО</b>	<b>57.00</b>
620001	Удирдах ажилтан	1.00
620002	Гүйцэтгэх ажилтан	48.00
620003	Үйлчлэх ажилтан	8.00

### 3. Аудитын тайлан

#### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Чингэлтэй дүүргийн халамжийн сангийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Эвиденсе аудит ХХК-ийн ахлах аудитор Б.Пушкин, аудиторын туслах Э.Билгүүн нар гүйцэтгэж, хяналтыг, ахлах аудитор С.Бадамгарав, НТАГ-ын аудитын менежер Д.Отгонбаяр, хэлтсийн дарга, аудитын менежер З.Мөнхбаяр нар тус тус хэрэгжүүлсэн.

Чингэлтэй дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтсийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Эвиденсе аудит ХХК-д 2022 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 1/140 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

#### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Чингэлтэй дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтсийн үйл ажиллагааны эрхэм зорилго нь “хөдөлмөрийн тухай, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай, нийгмийн халамжийн тухай багц хууль тогтоомжийн биелэлтийг орон нутгийн хэмжээнд хангуулан иргэдэд ёс зүйтэй мэргэжлийн үйлчилгээг үзүүлэх замаар ажилтай, орлоготой болгох, тэтгэвэр тэтгэмж, тусламж, хөнгөлөлт авах, асрамж, халамжийн үйлчилгээнд хамрагдах таатай нөхцөлийг бүрдүүлэх”-д оршино.

Чингэлтэй дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтсийн үйл ажиллагааны чиглэлийг нийгмийн халамж, хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээ, арга хэмжээг дүүрэгт зохион байгуулах, хэрэгжүүлэх, сурталчлах, хяналт тавих, жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих, төсөл хөтөлбөр хэрэгжүүлнэ гэж тодорхойлжээ.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрдөх хууль, тогтоомж, бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Сангийн сайдын 2021 оны 4 дүгээр тушаалаар батлагдсан “Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгийг ашиглах, эдгээр хөрөнгөөр санхүүжих төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх, зохион байгуулах, санхүүжүүлэх, хяналт тавих, үнэлэх журам”
- Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоол “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай”
- Сангийн сайдын 2021 оны 190 дугаар тушаалаар “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.



Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 САНХҮҮГИЙН ТАЙЛАГНАЛЫН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Чингэлтэй дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтсийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузел сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн байдлын тайлангийн нийт хөрөнгийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл бага гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 2.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны нийт хөрөнгийн 701,534.9 мянган төгрөгөөс 2.0 хувиар буюу 14,031.7 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80.0 хувиар буюу 11,225.3 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Чингэлтэй дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтсийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 35,103.7 мянган төгрөгөөр буюу 5 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

#### Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Авлага	58.1	2.0	(56.1)
Бараа материал	30,739.4	29,573.2	(1,166.2)
Үндсэн хөрөнгө	670,789.4	636,908.0	(33,881.4)
<b>Нийт хөрөнгө</b>	<b>701,586.9</b>	<b>666,483.2</b>	<b>(35,103.7)</b>
Өр төлбөр	52.0	28.3	(23.7)
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	701,534.9	666,454.9	(35,080.0)
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>701,586.9</b>	<b>666,483.2</b>	<b>(35,103.7)</b>

Бараа материалын дансны үлдэгдэл 29,573.2 мянган төгрөг болж 1,166.2 мянган төгрөгөөр буурсан нь түлш, шатах тослох материал, аж ахуйн материалын зардлаас шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 636,908.0 мянган төгрөг болж 33,881.4 мянган төгрөгөөр буурсан нь ашиглалтын хугацаа дууссан, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, ашиглалтын явцад сэргээн засварлаж ашиглах боломжгүй болсон хөрөнгийг Төрийн



өмчийн бодлого зохицуулалтын газрын 2021 оны 12 дугаар 30-ны өдрийн 722 дугаар тогтоолоор данснаас хассан нь шалтгаалжээ. Үндсэн хөрөнгийн данс нь урсгал төсвийн худалдан авалтаар 2,455.3 мянган төгрөг, хандиваар болон үнэ төлбөргүй шилжиж ирсэн 15,756.1 мянган төгрөгийн хөрөнгөөр нэмэгдсэн байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 666,454.9 мянган төгрөг болж 35,080.0 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

Чингэлтэй дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтсийн санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 19,443.6 мянган төгрөгөөр буюу 2.0 хувиар буурсан.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан төсөвт байгууллагын өөрийн орлого байна. Энэ нь тухайн байгууллагын нийгмийн даатгалын байгууллагаас авах тэтгэмж, мөн тендерийн орлого буурсан нь шалтгаалжээ.

Нийт зардал өмнөх оноос 34,288.0 мянган төгрөгөөр буюу 3.6 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан цалин, хөлс болон нэмэгдэл урамшил, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл, тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж зэрэг зардлууд байна. Энэ нь тайлант хугацаанд 2 ажилтан гавьяаны амралтад гарч 38,701.4 мянган төгрөгийн 1 удаагийн буцалтгүй тусламж үзүүлсэн байна. Гэрэл, цахилгаан болон байр ашиглалттай холбоотой зардлыг 4,970.3 мянган төгрөгөөр хэмнэж ажилласан байна

### **3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **3.6.1 Төсвийн төлөвлөлт**

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг болон нийт зарлагыг 1,119,662.2 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 225,088.2 мянган төгрөгөөр бууруулж 894,574.0 мянган төгрөгөөр баталсан байна.

#### **3.6.2 Төсвийн гүйцэтгэл**

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 5 хөтөлбөрийн 9 арга хэмжээг санхүүжүүлэхээр 894,574.0 мянган төгрөгийн төсөв баталснаас 894,574.0 мянган төгрөгийг улсын төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 894,574.0 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 892,798.4 мянган төгрөгийг зарцуулж, 1,775.5 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 892,798.4 мянган төгрөг буюу 99.7 хувьтай байгаа нь бараа, үйлчилгээний зардлыг 1,740.7 мянган төгрөгөөр дутуу зарцуулсантай холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.



### 3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгөөр 19,000.0 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөрт 11,000.0 мянган төгрөг, хангамж, бараа материалын зардалд 8,000.0 мянган төгрөг, нийт 19,000.0 мянган төгрөгийг зарцуулжээ.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### 3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

#### Асуудлыг онцолсон хэсэг:

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

#### Бусад асуудлын хэсэг:

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 5 зорилтын хүрээнд 9 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 100% хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна.

Шалгагдагч байгууллагын санхүүгийн тайлангаас бусад үйл ажиллагааны тайлан, мэдээ, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт зэрэг мэдээлэлтэй танилцсан болно. Ингэхэд материаллаг буруу илэрхийлсэн зүйл илрээгүй тул аудит хийсэн санхүүгийн тайланд залруулга хийх шаардлагагүй гэж үзлээ.

### 3.8 Аудитын гол асуудал

Чингэлтэй дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтсийн санхүүгийн тайлангийн аудитад нөлөөлөх гол асуудал байхгүй байна.

### 3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

#### 3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан 17 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.



Чингэлтэй дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтсийн 2021 оны санхүүгийн тайлан  
Чингэлтэй дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтэс нь 2021 онд нийт  
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан  
933,574.0 мянган төгрөгийн 17 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод  
байршуулахаас 933,574.0 мянган төгрөгийн 17 мэдээллийг хугацаандаа мэдээлсэн байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль, тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна.

### **3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2021 оны А/111 дүгээр тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас 2021-2022 онд гүйцэтгэх санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл”-ийн дагуу шалгагдагч байгууллагаас авсан судалгааг нэгтгэн дүгнэхэд “Халамжаас хөдөлмөрт” уриан доор нийслэлийн 6 дүүргийн сурталчилгаа, телевизийн нэвтрүүлгийн төлбөрт 10,000 мянган төгрөгийг “Яруу интернейшнл ХХК” -д шилжүүлсэн байна.

Үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас (цалин хөлс, нийгмийн даатгалын шимтгэл, ашиглалтын зардал) бусад төрлийн зардлыг 10-аас доошгүй хувь буюу 1,106,8 мянган төгрөгөөр зардлыг хэмнээгүй нь Засгийн газрын “Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 2021 оны 43 дугаар тогтоолын 1.1. “үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл, арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх зэргээр батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах;” 1.9 “бичиг хэрэг, албан хэрэг хөтлөлтийг байгууллагын дотоод сүлжээнд цахим хэлбэрт шилжүүлэх замаар бичиг хэрэг, цаас, хувилагч, хэвлэгчийн хорны зэрэг зардлыг бууруулах” заалтыг зөрчсөн, санхүүгийн тайлангийн “нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэв.

Тайлант онд Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зохион байгуулахад худалдан авалт хийгдээгүй байна.

### **3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

#### **3.10.1. Завсрын аудитын үр дүн:**

2021 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланд хийсэн завсрын аудитаар алдаа зөрчил илрээгүй.

#### **3.10.2. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт:**

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар алдаа зөрчил илрээгүй.

### **3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал**

Дээд шатны байгууллагуудын гаргасан тогтоол шийдвэрийг хангаж ажиллаж байгааг.

## **4. Аудитын илрүүлэлт**

Аудитаар санхүүгийн тайлагналтай холбоотой алдаа, зөрчил илрээгүй болно.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Алдаа, зөрчлийн товч утга	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал:											
1	Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоол "Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай" тогтоолыг хэрэгжүүлж ажиллаагүй.							1	1,106.8		
	<b>Дүн</b>							<b>1</b>	<b>1,106.8</b>		
	<b>Нийт дүн</b>							<b>1</b>	<b>1,106.8</b>		

Аудитын тайланг хянасан:

Эвиденсе аудит ХХК-ийн захирал

Бэлтгэсэн:

Ахлах аудитор

Аудиторын туслах

  
 С.Бадамгарав. Бадамгарав  
 Б.Пушкин  
 Э.Билгүүн